

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ

12 бүлэг 45 зүйл

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Хуульч М.Үүрийнтуяа

Сургалтын агуулга

- Монгол Улсын Үндсэн хууль
- Олон Улсын гэрээ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- Хууль, тогтоомжийн бусад акт

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчим болоод харилцааг зохицуулж буй хэм хэмжээний талаар ойлголттой болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх вэ ?

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

Ялгаварлан гадуурхалт гэж юу вэ ?

Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.

“түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Үндсэн хуулийн 16 дугаар зүйл



Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох зэрэг эрхүүдийг эдлэх эрхтэй. Өнөөдрийн сэдвээр тухайлан авч үзэх эрх бол ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрх тэгш байх эрхийн тухай юм.



ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци
2. Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай марракешийн гэрээ



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх үүрэгтэй.

- Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй.
- Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

- Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна.
- Аж ахуйн нэгж, байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө. Уг үүргээ эс биелүүлсэн тохиолдолд зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

- Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.
- Цалин хөлс олгож байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг хориглоно.




ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН ХАМРУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ

Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.





ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮНИЙ БУСАД ЭРХ


- 
1. Хууль зүйн туслалцаа авах эрх
 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх
 3. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх
 4. Хувийн нууцаа хамгаалуулах эрх
 5. Бие даан амьдрах эрх
 6. Биеийн тамир, спортын үйл ажиллагаагаар хангагдах эрх
 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцох эрх
 8. Онцгой байдлын үед мэдээллээр хангагдах, хамгаалагдах эрхтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах орчин

Хот байгуулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд **“хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох”** журмыг баримтална. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журамд заасныг баримтлах.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохгүй байх

Зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хууль 12.5 дугаар зүйлийн 2.2 дах хэсэгт зааснаар хариуцлага тооцно.

- 
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага хамтран 2019-2020 онд “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал” сэдвээр мэдээлэл, лавлагааны материал бэлтгэн гаргасан.
Уг судалгаагаар:

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.7 мянган иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46.0 мянга нь эмэгтэйчүүд байна. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.4 хувь нь төрөлхийн, 55.6 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.



Хэлэлцүүлэгийн цаг



Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн **албан тушаалтны үйлдэл нь** гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- Хүн, хуулийн этгээдийн гаргасан хууль бус үйлдэлд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Анхаарал хандуулсанд
баярлалаа!